

“АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

П.МӨНХ-ЭРДЭНИЙН 03 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

2021 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2021 оны 03 дугаар улирлын ажлын тайланг хүргүүлж байна. Тайлант хугацаанд Ариг банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал, хойшлогдсон хурал 3 удаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 10 удаа хуульд заасны дагуу танхимаар, цахимаар, эчнээ санал хураалтын хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнээс:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2021 оны 08 дугаар сарын 05 өдөр зарлан хуралдуулж, хурлын даргаар томилогдон ажилласан, хурал хууль болон дүрэмд заасан ирц бүрдээгүй учир хойшлогдсон хурлыг зарлан хуралдуулсан.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хойшлогдсон хурлыг 2021 оны 08 дугаар сарын 18 өдөр зарлан хуралдуулж хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсэн. Үүнд:
 - Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан төлөвлөгөөг хэлэлцүүлж батлуулан Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороонд хүргүүлсэн.
 - Ариг банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж дүрмийн шинэчилсэн найруулгад тусган хянуулж батлуулан зөвшөөрлийг авахаар Монголбанк руу хүргүүлсэн.
- Ариг банкны ТУЗ-ийн гишүүдийг хуульд заасан орон тооны дагуу бүрдүүлэн ажиллуулах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2021 оны 09 дүгээр сарын 23 өдөр зарлан хуралдуулсан, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас томилогдсон хурлын даргыг чөлөөлж, шинээр томилсон, хурлын ирц хууль болон дүрэмд заасан хувь хэмжээнд хүрээгүй учир хойшлогдсон хурлыг зарлаагүй, Монголбанкны 2021 оны 09 сарын 20 өдрийн А-6/945 тоот албан бичгийг үндэслэн хэлэлцэх асуудлыг нэмэгдүүлж, дахин шинээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2021 оны 10 сарын 04 өдөр хуралдуулахаар зарласан.
- 2021 оны 07 дугаар сард нийт 3 удаа хуралдаж, дараах асуудлуудыг хэлэлцэж, холбогдох тогтоолуудыг гаргасан болно.
 - 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр ТУЗ-ийн дэргэдэх хороодыг Компанийн тухай хуульд заасны дагуу байгуулж, “ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах тухай” Т/17 дугаар тогтоол;
 - 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдөр “Банкны гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалт явуулах тухай” Т/18 дугаар тогтоол;
 - 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлахаар шийдвэрлэсний дагуу “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлыг батлах тухай” Т/20 дугаар тогтоол мөн “Номин Тав Трейд” ХХК-ийн ажиллагсдад цалингийн карт олгох асуудлаар “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай” Т/21 дугаар тогтоолыг батласан.
- 2021 оны 08 дугаар сард нийт 2 удаа хуралдаж, дараах асуудлуудаар тогтоол гаргасан болно.
 - 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц бүрдээгүй тул 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит

- хурлыг хойшлуулан товлох тухай” Т/22 дугаар тогтоолыг батлаж, “Гүйцэтгэх захиралд ээлжийн амралт олгох, орлон ажиллах хүнийг томилох тухай” Т/23 дугаар тогтоолыг гаргасан.
- 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Гүйцэтгэх захирал Б.Ариунжаргалын хүндэтгэн үзэх шалтгааны улмаас чөлөө олгох тухай хүсэлтийг хэлэлцэж, “Гүйцэтгэх захиралд чөлөө олгох тухай” Т/24 дүгээр тогтоолыг батласан.
 - 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл ББСБ” ХХК-тай Дархан тооцооны төвийн түрээсийн байрыг үргэлжлүүлэн түрээслэхтэй холбогдуулан, “Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай” Т/25 дугаар тогтоол, “Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай” Т/26 дугаар тогтоол, “Түрээсийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” Т/27 дугаар тогтоолыг батласан.
 - Мөн өдрийн хурлаар “Банкны чанаргүй активыг бууруулах стратеги батлах тухай” Т/28 дугаар тогтоол, “Өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах зөвшөөрөл олгох тухай” Т/29 дүгээр тогтоолуудыг хэлэлцэн батласан.
- 2021 оны 09 дүгээр сард нийт 5 удаа хуралдсан ба дараах асуудлуудыг хэлэлцэж, холбогдох тогтоолуудыг гаргасан болно.
- 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлыг батлах тухай” Т/30 дугаар тогтоол, “Түрээсийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” Т/31 дүгээр тогтоол, “Мэдээллийн технологийн аудитор томилох тухай” Т/32 дугаар тогтоол, “ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох тухай” Т/33 дугаар тогтоол;
 - 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр “Дэд захирал томилох эрх олгох тухай” Т/34 дүгээр тогтоол;
 - 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр “ХЭЭБХ-ын даргыг дахин томилох тухай” Т/35 дугаар тогтоол;
 - 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлыг батлах тухай” Т/36 дугаар тогтоол;
 - 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр “Хурлын даргыг дахин томилох тухай” Т/37 дугаар тогтоол, “Хурлын нарийн бичгийн даргыг томилох” Т/38 дугаар тогтоол тус тус гарган батлаж, 2021 оны 03 дугаар улиралд дээрх хурлуудаас нийт 22 тогтоол гарган ажилласан.

Түүнчлэн “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргаар, Эрсдэл удирдлагын хороо болон Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр болон 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Эрсдэл удирдлагын хорооны хуралд оролцож ажилласан.

- 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн хурлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд байгаа 7 зээлдэгчийн зээлийн төлбөрийг төлүүлэх явцыг хэлэлцэн, 3 зээлдэгчийн төлбөрийг шийдвэрлэх талаар тогтоол гаргасан.
- 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар ХТАГ-т бүртгэгдсэн ӨБХ-ийн нөхцөл байдлын мэдээлэлтэй танилцаж хурлаар оруулсан 4 асуудлыг эцэслэн шийдвэрлэж тогтоол гаргасан.

ТАЙЛАН БИЧСЭН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

хараат бус гишүүн П.Мөнх-Эрдэнэ